



МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 01 сарын 05 өдөр

Дугаар A/02

Улаанбаатар хот

Түр журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.1, 6.1.4, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний сайдын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар батлагдсан "Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах түр журам"-ын 4.8 дахь хэсгийг дараах байдлаар өөрчилсүгэй.

"4.8. Шинээр холбогдсон, халаалтаа цахилгаанаар бүрэн шийдсэн, ижил төстэй хэрэглэгчийн өмнөх оны мөн үеийн дунджаас бага хэрэглээтэй байсан, гэрээний эзэмшигч өөрчлөгдсөн хэрэглэгчийн төрөөс хариуцах төлбөрийн хэмжээг тухайн хэрэглэгчийн хэрэглээний гүйцэтгэлийг харгалzan ижил төстэй айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын дундаж хэрэглээтэй дүйцүүлж тогтооно."

2. Журамд орсон өөрчлөлтийг мөрдөж ажиллахыг эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэр, компаниудын гүйцэтгэх захирал, дарга наарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б. Насантогтох/-д даалгасугай.



Н.ТАВИНБЭХ

170600010



МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.1, Захиргааны өрөнхий хуулийн 70.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас айл өрх, зарим аж ахуй нэгж, байгууллагуудын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөрийг төрөөс хариуцах болсонтой холбогдуулан “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах түр журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэр, компаниудын гүйцэтгэх захирал, дарга нарт даалгасугай.

3. Энэхүү журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Р.Батрагчаа/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Насантогтох/-д даалгасугай.



Н.ТАВИНБЭХ

170600651

Эрчим хүчний сайдын 2020 оны 12 дугаар сарын  
16.-ны өдрийн 07 дугаар тушаалын хавсралт



## ЦАХИЛГААН, ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ, ДУЛААНЫ УУРЫН ХАНГАМЖ, ХЭРЭГЛЭЭГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн Газраас айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллага /цаашид хэрэглэгч гэх-/ын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд төрөөс хариуцахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хангамж, хэрэглээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангахад энэхүү түр журмыг мөрдөнө.

1.2. Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хангамжийн эх үүсвэр болон шугам сүлжээний техникийн хүчин чадлын боломжтой уялдуулан хэрэглэгчдийн цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хэрэглээг хянаж зохицуулна.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Цахилгаан, дулааны эрчим хүч, үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, импортлох, диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчид, айл өрх болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага энэхүү журмыг мөрдөнө. Үүнд:

- Төсөвт байгууллага;
- Төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээд;
- Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр;
- Банк, банк бус санхүүгийн байгууллага;
- Криптовалюттай холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- Интернет, үүрэн холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- Согтууруулах ундаа, тамхи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- Өнгөт металл болон хар төмөрлөг, цементийн үйлдвэр;

### Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1.1. Эх үүсвэр, шугам сүлжээний техникийн хүчин чадлын боломжтой уялдуулан үйлдвэрлэл, хэрэглээний онцгой үеийн горимыг төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

3.1.2.Хэрэглээ огцом өсөх, нэгдсэн сүлжээнд тасралт, саатал гарах, импортын цахилгаан эрчим хүч техникийн боломжит хэмжээнээс хэтрэх, чадлын дутагдалд орох, зэрэг нөхцөл байдал үүссэн үед хэрэглэгчдийн эрчим хүчийг хязгаарлах графикийг хэрэгжүүлж, төвийн бусийн нэгдсэн сүлжээний тогтвортой найдвартай ажиллагааг хангаж ажиллах.

3.1.3.Баруун бусийн эрчим хүчний систем, Дорнод бусийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн эрчим хүчний системийн технологийн үйл ажиллагаанд хяналт тавьж шуурхай удирдлагаар хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллах.

3.2.Эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.2.1.Диспетчерийн графикийг мөрдөж ажиллах, хэрэглээний огцом өөрчлөлт бий болох, нэгдсэн сүлжээнд тасралт, саатал гарч, импортын урсгал хэтрэх, чадлын дутагдалд орох үед техникийн боломжит хүчин чадлаар оролцох.

3.2.2.Үндсэн болон туслах тоноглолын ажиллагааны бэлэн байдлыг хангаж, түлш болон сэлбэг материалын зохих нөөцийг бүрдүүлж ажиллах.

3.3.Цахилгаан дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.3.1.Онцгой үеийн горимыг мөрдөж дамжуулах, түгээх сүлжээний тогтвортой найдвартай ажиллагааг хангаж ажиллах.

3.3.2.Шугам тоноглолын техникийн хүчин чадал, ачаалал, хэрэглээний өөрчлөлтөд 24 цагийн турш хяналт тавьж, холбогдох техникийн арга хэмжээг авч ажиллах.

3.3.3.Хэрэглээний өсөлтөөс шалтгаалан шугам, трансформаторын ачаалал зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд хэт ачаалалд орсон шугам, тоноглолын ачааллыг шилжүүлэх, боломжгүй үед хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчийг хязгаарлах арга хэмжээ авах.

3.3.4.Хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөд аюул учрах, гал түймэр гарах нөхцөл бүрдсэн үед хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдэхгүйгээр цахилгаан хангамжийг таслах арга хэмжээ авч, үүссэн нөхцөл байдлыг арилгах.

3.3.5.Нэгдүгээр зэрэглэлийн болон онцгой хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчийг хязгаарлахгүй байх.

3.3.6.Криптовалютын хэрэглээ, ачаалал байгаа эсэхийг тодруулах зорилгоор хэрэглэгчийн эзэмшлийн шугам сүлжээнд хангаж байгууллагаас үзлэг шалгалт хийж холбогдох арга хэмжээ авах.

3.3.7.Түр журмын үйлчлэх хугацаанд цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор сэлбэг, материалын нэмэлт нөөцийг бүрдүүлэх.

3.3.8.Хэрэглэгчдэд эрчим хүчийг цахилгаан түгээх шугам, тоноглолын хүчин чадлын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй, зүй зохистой, хэмнэлттэй хэрэглэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах.

3.3.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчдийн дуудлага, гомдол хүсэлтийг түргэн шуурхай барагдуулах.

3.4.Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.4.1.Батлагдсан горимыг мөрдөж дамжуулах, түгээх сүлжээний тогтвортой найдвартай ажиллагааг хангаж ажиллах, гарсан гэмтэл saatlyg шуурхай арилгах.

3.4.2.Худалдан авах болон хэрэглэгчдэд түгээх дулааны эрчим хүчиний төлөвлөгөө болон батлагдсан горимыг мөрдөж ажиллах, хэрэглэгчдийг чанарын шаардлагад нийцсэн дулааны эрчим хүчээр хангах.

3.4.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчдийн дуудлага, гомдол хүсэлтийг түргэн шуурхай барагдуулах.

#### **Дөрөв. Хэрэглэгчийн эрх, үүрэг**

4.1.Энэхүү журмын 2.1-д зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэгч нь цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөрийн өмнөх оны мөн үеийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний төлбөрийг төрөөс хариуцуулах эрхтэй.

4.2.Хэрэглэгч нь цахилгаан эрчим хүчийг зүй зохистой, хэмнэлттэй хэрэглэх, өөрийн шугам, тоноглолын техникийн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхгүй байх үүрэгтэй

4.3.Хэрэглэгч стандартын шаардлага хангасан тоолуур, цахилгаан хэрэгсэлтэй байх бөгөөд цахилгааны болон галын аюулгүй ажиллагааг хангасан байна.

4.4.Хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллага нь цахилгааны оргил ачааллын үед буюу өдөр бүрийн 17:00-21.00 цагийн хооронд өөрийн хэрэглээг 20-оос доошгүй хувиар бууруулна.

4.5.Хэрэглэгч айл өрх нь цахилгааны оргил ачааллын үед буюу өдөр бүрийн 17:00-21:00 цагийн хооронд цахилгаан халаагуурыг ашиглахгүй байх үргийг хүлээнэ.

4.6.Хэрэглэгч нь түр журам мөрдөгдөх хугацаанд мэргэжлийн байгууллагын шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.7.Эрчим хүчиний эх үүсвэр болон шугам сүлжээний техникийн хүчин чадлын боломжит хэмжээтэй уялдуулан төлбөрийг төр хариуцах цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хэмжээг өмнөх оны мөн үеийн хэрэглээнээс хэтрүүлэхгүй байхаар тооцно. Хэтэрсэн эрчим хүчиний төлбөрийг одоогийн мөрдөгдөж буй тарифаар тооцож хэрэглэгч өөрөө төлнө.

4.8 Шинээр холбогдсон хэрэглэгчийн төрөөс хариуцах төлбөрийн хэмжээг тооцохдоо тухайн хэрэглэгчийн хэрэглээний гүйцэтгэлийг харгалзан ижил төстэй айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын дундаж хэрэглээтэй дүйцүүлж тооцно.

## **Тав. Хяналт, хариуцлага**

5.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Мэргэжлийн хяналтын болон Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагатай хамтран хэрэглэгчийн цахилгаан тоноглолын аюулгүй байдалд хяналт тавина.

5.2. Хэрэглэгч цахилгааны хэрэглээгээ техникийн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлсний улмаас шугам, тоноглолд гэмтэл гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

--- оОо ---